



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/129

Булган сум

Мэдээллийн түц ажиллуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66.1 дэх заалт, Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Шинэ сэргэлтийн бодлого", Монгол улсын Засгийн газрын 2022 оны 419 дүгээр "Хот хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай" тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хөдөөгийн сэргэлт" чуулганд "НЭЭЛТТЭЙ АЙМАГ МЭДЭЭЛЛИЙН ТҮЦ" байгуулах ажлыг 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсугай.

2. НЭЭЛТТЭЙ АЙМАГ-МЭДЭЭЛЛИЙН ТҮЦ ажиллуулах удирдамжийг 1 дүгээр, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. НЭЭЛТТЭЙ АЙМАГ-МЭДЭЭЛЛИЙН ТҮЦ-ийг ажиллуулан, аймаг орон нутгийн онцлогийг сурталчлан, Улаанбаатар хотод иргэдэд мэдээлэл хүргэн ажиллахыг аймгийн дэд ажлын хэсэгт даалгасугай.

4. Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 5,560,000 (таван сая найман зуун мянга) төгрөгийг "Хот хөдөөгийн сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх Нээлттэй Булган" хөтөлбөр арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2023 оны
03 дугаар сарын 07-ны өдрийн А/29 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТ ЧУУЛГАНД “НЭЭЛТТЭЙ АЙМАГ-МЭДЭЭЛЛИЙН ТҮЦ” АЖИЛЛУУЛАХ УДИРДАМЖ

Зорилго: “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын зорилтын хүрээнд “Улаанбаатар хотоос шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжийг дэмжих чиглэлээр Засгийн газраас “Хот хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 2022 оны 419 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд “Хөдөөгийн сэргэлт” чуулганд Улаанбаатар хотод оролцоно.

Чуулганы үеэр “НЭЭЛТТЭЙ АЙМАГ-МЭДЭЭЛЛИЙН ТҮЦ” ажиллуулж, орон нутгийн онцлог, давуу тал, шилжин суурьшигчдыг хүлээж авах бодлого төлөвлөлтөө танилцуулж, иргэд, олон нийтээс сонирхсон асуултад хариулт өгч мэдээлэл хүргэнэ.

Мэдээллийн агуулга:

1. Дахин төлөвлөх замаар шинээр суурьшлийн бүс байгуулах талаар
2. Иргэдийн амьдрах байр, орон сууцны хүрэлцээ, хангамж
3. Иргэд, аж ахуй нэгж байгууллагад газар олгох боломж, хүртээмж
4. Томоохон бүтээн байгуулалтын ажил, төсөл хөтөлбөрүүд, шинээр ажлын байр нэмэгдүүлэх боломж
5. Орон нутагт шинээр салбараа нээж ажлын байр нэмэгдүүлж байгаа аж ахуйн нэгжүүдэд орон нутгийн зүгээс дэмжлэг үзүүлэх чиглэл
6. Иргэд, аж ахуй нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд чиглэсэн хөнгөлөлттэй зээл олголт, дэмжлэг туслалцаа
7. Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж
8. Бүх шатны боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж
9. Аялал жуулчлалын хөгжүүлэхэд чиглэсэн бизнес хөгжүүлэх боломж
10. Хөдөө аж ахуй, газар тариалан эрхлэх боломж, хүртээмж

Хамрах хүрээ:

Аймгийн Засаг даргын тамгын газар
Сумдын Засаг даргын тамгын газрууд
Байгаль орчин аялал жуулчлалын газар
Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
Хүнс хөдөө аж ахуйн газар
Боловсрол шинжлэх угааны газар
Соёл урлагийн газар
Хөдөлмөр халамж үйлчилгээний газар
Эрүүл мэндийн газар
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
Татврын хэлтэс
Улсын бүртгэлийн хэлтэс
Хугацаа: 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 14:00-17:40 цагт

Байршил: Нийслэлийн Соёлын төв өргөөний 2 давхарт аймаг тус бүрд 3*1 хэмжээтэй, нэгдсэн брендинг хаягжилттай, мэдээлэл танилцуулах талбайд

Аймгийн Засаг даргын 2023 оны
03 дугаар сарын 27-ны өдрийн ХА29... дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт



ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТ ЧУУЛГАНД "НЭЭЛТТЭЙ АЙМАГ-МЭДЭЭЛЛИЙН ТҮЦ"
АЖИЛЛУУЛАХ ТӨСӨВ

Д/д	Шаардлагатай зардал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Үнэ /төгрөг/	
				Нэг бүр	Нийт
1	2	3	4	5	6
1	Шатахуун	Км/л	4 машин*992,5 нийт 3970 км нийт 714 литр	2520	1.800.000
2	Айраг	Л	100	7500	750.000
3	Цагаан идээ	Кг	2	25000	50.000
4	Нэг удаагийн аяга	Ширхэг	200	150	30.000
5	Хэвлэлийн эх бэлтгэл	Ширхэг	20	17500	350.000
6	Товхимол хэвлүүлэх	Ширхэг	150	6000	900.000
7	Фодволк хэвлэл	Ширхэг	15	32000	480.000
8	Аймгийн цахим хуудасны мэдээлэл шинэчлэх	Агуулга	16	75000	1.200.000
НИЙТ				5.560.000	